



**ҮЙЛДВЭР, ХӨДӨӨ АЖ АХУЙН ЯАМНЫ
ТӨРИЙН НАРИЙН БИЧГИЙН ДАРГЫН
ТУШААЛ**

2014 оны 06 сарын 09 өдөр

Дугаар А/1224

Улаанбаатар хот

Төсөлд дэмжлэг үзүүлэх тухай

“Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай” хуулийн 46 дугаар зүйлийн 46.1.3 дахь заалтыг баримтлан Монгол Улсын Засгийн газрын 2003 оны 160 дугаар тогтоолоор баталсан “Эрчимжсэн мал аж ахуйн хөгжлийг дэмжих хөтөлбөр”-ийн 5.2.2, 5.2.7 дахь заалтууд, Эрчимжсэн мал аж ахуйн чиглэлээр худалдан авах бараа, ажил, үйлчилгээний нийлүүлэгчийг сонгох тендерийн үнэлгээний хорооны 2004 оны 05 дугаар сарын 27-ны өдрийн 9 дүгээр хурлын тэмдэглэл, 05 дугаар сарын 28-ны өдрийн 07/2144 тоот зөвлөмжийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Нарийн ноост хонины болон Махны чиглэлийн хонь бордох аж ахуйг өргөтгөх хөнгөлөлттэй зээлийн дэмжлэгт хамрагдах аж ахуй нэгжүүдийн нэр, олгох санхүүжилтийг нэгдүгээр хавсралтаар баталсугай.

2. Төслийн шалгаруулалтад тэнцсэн аж ахуйн нэгжүүдэд олгох санхүүжилтэд шаардагдах нийт 1.500.000.000 /Нэг тэрбум таван зуун сая/ төгрөгийг Үйлдвэр, хөдөө аж ахуйн сайдын 2013 оны 12 дугаар сарын 12-ны өдрийн А/163 дугаар тушаалын 05 дугаар хавсралтын 5.3.1-т заасан “Эрчимжсэн мал аж ахуйн хөгжлийг дэмжих хөтөлбөр”-ийг 2014 онд хэрэгжүүлэх арга хэмжээний зардлаас санхүүжүүлэхийг Мал хамгаалах сангийн захирал П.Мөнхбаярт зөвшөөрсүгэй.

3. Хавсралтад дурдсан аж ахуйн нэгжүүдтэй барьцаа хөрөнгө болон төсөл хэрэгжүүлэх чадвартай нь уялдуулан, 5 жилийн хугацаатай, жилийн 2.4 хувийн хүүтэй, зээлийн гэрээ байгуулах, буцаан төвлөрүүлэх арга хэмжээг авч, ажиллахыг Мал хамгаалах сан /П.Мөнхбаяр/-д, шалгарсан аж ахуйн нэгжийн төслийн хэрэгжилт, үр дүнд хяналт тавьж ажиллахыг Мал аж ахуйн бодлогын хэрэгжилтийг зохицуулах газар /Н.Ганибал/-т тус тус үүрэг болгосугай.


ДАРГА



Х.ЗОЛЖАРГАЛ

60000795

Үйлдвэр, хөдөө аж ахуйн яамны
Төрийн нарийн бичгийн даргын
2014 оны 06 дугаар сарын 09-ны
өдрийн 01/0224 дүгээр тушаалын хавсралт



**НАРИЙН НООСТ ХОНИНЫ БОЛОН МАХНЫ ЧИГЛЭЛИЙН ХОНЬ БОРДОХ
АЖ АХУЙГ ӨРГӨТГӨХӨД ШАЛГАРСАН АЖ АХУЙН НЭГЖИЙН НЭРС**

№	Аймаг	Сум, дүүрэг	Иргэн, аж ахуйн нэгжийн нэр	Олгох мөнгөн дүн
1	Архангай	Их тамир	“Арчандаган” Хоршоо	20.0
2	Архангай	Өлзийт	“Галт дэлгэрэх” ХХК	15.0
3	Баянхонгор	Өлзийт	“Эхэн цохио” Хоршоо	15.0
4	Говьсүмбэр	Сүмбэр	“Говийн өндөр уул” Хоршоо	20.0
5	Говь-Сүмбэр	Сүмбэр	“Хүү гэгээ” ХХК	15.0
6	Дорнод	Чулуун хороот	“Шавардай Баянхан” ХХК	15.0
7	Дорнод	Чулуун хороот	“Хишигт-Эрхэс” ХХК	25.0
8	Дорнод	Баян-Уул	“Тунагурван-Өндөр” ХХК	20.0
9	Дорнод	Цагаан-Овоо	“Нарлагталын чандмань” ХХК	20.0
10	Дорнод	Баян-Уул	“Алтайтаван эрдэнэ” ХХК	25.0
11	Дундговь	Сайнцагаан	“Ихбага хаалган” Хоршоо	15.0
12	Завхан	Дөрвөлжин	“Бугат хайрхан уул” ХХК	20.0
13	Орхон	Баян-Өндөр	“Мөнгөн тэнгис” ХХК	15.0
14	Орхон	Баян-Өндөр	“Эрдэнэтгөгөл” ХХК	10.0
15	Өвөрхангай	Арвайхээр	“Арвайн барилга” ХХК	10.0
16	Сүхбаатар	Баруун-Урт	“Баянмөнх ундрах” Хоршоо	10.0
17	Сэлэнгэ	Баянгол	“Баядсүрэг” Хоршоо	20.0
18	Сэлэнгэ	Жавхлант	“Тариатын буудай” ХХК	15.0